



ГАРЫН АВЛАГА

ОНЛАЙН АРИЛЖААНЫ СИСТЕМ



АГУУЛГА

1 НЭВТРЭХ ХЭСЭГ.....	Хуудас 4
2 ЗАХ ЗЭЭЛ.....	Хуудас 5
3 ДАНС.....	Хуудас 6
4 ЗАХИАЛГА.....	Хуудас 8
5 ГРАФИК ШИНЖИЛГЭЭ.....	Хуудас 10
6 АРИЛЖАА.....	Хуудас 11
7 МӨНГӨ ХҮСЭХ ӨРГӨДӨЛ.....	Хуудас 12
8 ШУУДАН.....	Хуудас 13


ТАНИЛЦУУЛГА

Онлайн арилжааны систем нь Монголын хөрөнгийн биржийн арилжааны системтэй шууд холболттой, ашиглахад хамгийн хялбар, цогц онлайн брокерын үйлчилгээ юм. Тус үйлчилгээг ашигласнаар уламжлалт брокерын үйлчилгээ буюу харилцагч биеэр брокерт хандан авдаг байсан үйлчилгээнүүдийг зайнаас /онлайн/ интернет холболт бүхий мэдээллийн технологи, харилцаа холбооны төхөөрөмж /компьютер, таблет, гар утас гэх мэт/ ашиглан үйлчилгээнд нэвтэрч цаг хугацааны хоцрогдолгүй үнэт цаасны арилжаанд оролцох, үнэт цаасны арилжааны захиалгын санг харах, төлбөр тооцоо болон үнэт цаасны дансаа хянах, зарлагын гүйлгээ гаргах, техник шинжилгээ хийх, мэргэжлийн шинжээчдийн судалгааны үр дүнтэй танилцах, мэдээ мэдээлэл тогтмол авах гэх мэт үйлчилгээнүүдийг авах боломжийг бүрдүүлсэн бөгөөд харилцагчийн цаг хугацааг хэмнэсэн дэвшилтэт үйлчилгээ юм.

The advertisement features the TDB Capital logo at the top left, consisting of a circular icon with three arrows and the text "TDB CAPITAL". To the right of the logo, the word "UPGRADED" is written in a smaller font. Below this, the main title "ONLINE TRADING PLATFORM" is displayed in large, bold, white capital letters. The background is a solid blue color. In the foreground, there are three devices showing the trading platform interface: a tablet on the left, a laptop in the center, and a smartphone on the right. The tablet screen shows a login form with fields for "Хувьцаа" (Share) and "Хуучир" (Old), a "Зарим зохилго" (Some purpose) button, and a "Зарим зохилго" (Some purpose) button. The laptop screen displays a complex trading interface with multiple panels, including a "Сөрөгтэй бүх хувьцаа" (All negative shares) table, a "Зарим зохилго" (Some purpose) button, and a "Зарим зохилго" (Some purpose) button. The smartphone screen shows a "Шинээр мөнгө хураа" (New money collection) button, a "Төлбөр тооцооны" (Payment) button, a "ҮЦТХТ-ны данс" (VCTHT account) button, and an "АТТ-ын данс" (ATT account) button. The background of the advertisement is a solid blue color.


1. НЭВТРЭХ ХЭСЭГ

Та манай компанид үнэт цаасны данс нээлгэн онлайн брокерийн үйлчилгээ авснаар үйлчилгээнд нэвтрэх нэр болон нууц үг таны бүртгэлтэй имэйл хаягруу илгээгдэнэ. Тус и-мэйл нь үнэт цаасны данс нээлгэсэн өдөр info@tdbcapital.mn хаягаас ирнэ.




Хэрэв таны нэвтрэх нэр болон нууц үг ирээгүй бол SPAM хэсэгт давхар шалгах хэрэгтэй. Inbox, Spam алинд нь ч мэйл ирээгүй бол 70110261, 70100263 утсаар брокертой холбогдон лавлана уу.

Нэвтрэх нэр, нууц үгээ авсан бол www.tdbcapital.mn веб хуудсанд хандан баруун дээд буланд байрлах “Онлайн арилжаа” хэсгээр систем рүү нэвтэрнэ.



Доор харагдаж буй хэсэгт нэвтрэх нэр болон нууц үгээ оруулж үйлчилгээнд нэвтэрнэ. Харилцагч болон компанийг эрсдэлээс хамгаалах үүднээс, нэвтрэх нэр болон нууц үгийг харилцагч 3 удаа буруу оруулсан тохиолдолд харилцагчийн эрхийг автоматаар идэвхгүй болгоно. Идэвхгүй болсон тохиолдолд брокертой утсаар холбогдож эрхээ сэргээлгэх боломжтой. Харин нууц үгээ мартсан бол “Нууц үгээ мартсан” хэсэгрүү нэвтэрч хүсэлт илгээснээр өөрийн бүртгэлтэй цахим шуудангаар дамжуулан дахин нууц үг шинээр үүсгэн авах боломжтой.



САНАМЖ: Харилцагч нэвтрэх нэр, нууц үгийг бусдад дамжуулахгүй байх ба нууцлалын бүрэн бүтэн байдлыг бие даан хариуцна.

2. ЗАХ ЗЭЭЛ

Сонирхож буй хувьцаа / Watchlist

Энэ хэсэгт өөрийн сонирхож буй болон эзэмшиж буй үнэт цааснуудаа нэг самбарт оруулан, тэдгээрийн ханшийн хөдөлгөөн болон арилжааны мэдээллийг харна. Тус жагсаалтад та хэдэн ч тооны үнэт цаасыг нэмж, хасах боломжтой.

/Ханшийн мэдээллийн дэлгэрэнгүйг гарын авлагын хуудас 10-аас харна уу/

Сонирхож буй хувьцаа										
№	Үнэт цаас	Нээлт	Дээд	Доод	Сүүлийн ханш	Хаалт	Өмнөх өдрийн хаалт	Өөрчлөлт ₮	Өөрчлөлт %	
1	APU	597.00	597.00	590.00	590.00	590.67	595.01	-4.34	-0.729 %	✖
2	AIC	799.00	799.00	770.01	797.00	794.23	793.04	1.19	0.15 %	✖
3	MBW	340.00	340.00	325.00	339.00	338.38	338.40	-0.02	-0.006 %	✖
4	MNDL	4,850.00	4,992.00	4,850.00	4,992.00	4,986.00	4,811.00	175.00	3.637 %	✖

Захиалгын сан / Order book (LIVE)

Энэхүү захиалгын сан нь Монголын хөрөнгийн биржийн арилжааны үе болох 10:00-13:00 цагийн хооронд үнэт цааснуудын худалдах болон худалдан авах талд хэдэн захиалга, ямар үнийн саналтайгаар байршиж байгааг “Real-time” буюу цаг хугацааны хоцрогдолгүйгээр танд шууд дамжуулан харуулна. Эндээс та өөрийн сонирхож буй болон эзэмшиж байгаа үнэт цаасыг сонгож, үнэ ханшийн хөдөлгөөнийг хянах ба арилжааны шийдвэр гаргалтад зайлшгүй ашиглагдах цонх юм.

График шилжилт

Арилжав

Мөнгө хүсэх өргөдөл

Шуудан

Мэдээлэл

3	MBW		340.00	340.00	325.00	339.00	338.38	338.40	-0.02	-0.006 %	✖
4	MNDL		4,850.00	4,992.00	4,850.00	4,992.00	4,986.00	4,811.00	175.00	3.637 %	✖
5	GOV		33 780.00	33 880.00	33 700.00	33 700.00	33 760.00	33 460.00	300.00	0.897 %	✖

Захиалгын сан

GOV - ГОВЬ ✖

Өмнөх өдрийн хаалт 33,460.00

Нээлт 33,780.00 ↑ Дээд 33,880.00 ↓ Доод 33,700.00

№	Авах үнэ	Авах тоо	№	Зарах үнэ	Зарах тоо
1	33,300.00	100	1	33,900.00	86
2	33,240.00	2	2	34,000.00	3
3	33,200.00	1	3	34,000.00	57
4	33,200.00	20	4	34,000.00	7
5	33,100.00	2	5	34,100.00	17
6	33,000.00	3	6	34,160.00	100
7	32,700.00	11	7	34,500.00	60
8	32,000.00	13	8	34,500.00	433
9	31,500.00	22	9	34,500.00	98

Захиалгын сан

TTL - ТАВАН ТОЛГОЙ ✖

Өмнөх өдрийн хаалт 7,810.00

Нээлт 7,700.00 ↑ Дээд 7,700.00 ↓ Доод 7,660.00

№	Авах үнэ	Авах тоо	№	Зарах үнэ	Зарах тоо
1	7,660.00	10	1	7,850.00	1,000
2	7,610.00	197	2	7,900.00	359
3	7,600.00	250	3	8,000.00	36
4	7,600.00	2	4	8,000.00	10
5	7,600.00	30	5	8,000.00	3
6	7,515.00	5	6	8,500.00	20
7	7,500.00	27	7	8,625.00	5
8	7,305.00	5	8	8,800.00	200
9	7,300.00	133	9	8,850.00	20

Захиалгын сан

AIC - АРД ДААТГАЛ ХК ✖

Өмнөх өдрийн хаалт 793.04

Нээлт 799.00 ↑ Дээд 799.00 ↓ Доод 770.01

№	Авах үнэ	Авах тоо	№	Зарах үнэ	Зарах тоо
1	775.00	600	1	800.00	13,000
2	770.02	127	2	800.00	8,835
3	770.02	860	3	800.00	6,300
4	770.00	50	4	800.00	500
5	770.00	4,000	5	800.00	557
6	760.00	90	6	838.00	5,005
7	760.00	6,100	7	840.00	420
8	750.00	78	8	840.00	301
9	750.00	199	9	840.00	12,530



<- Энэ зурган дээр дарснаар захиалгын цонхруу шилжинэ.

3. ДАНС

Онлайн үйлчилгээний эрх

Энэ талбарт таны онлайн үйлчилгээний эрхийн хүчинтэй хугацааг харуулна. Үйлчилгээний эрх дууссан тохиолдолд “Эрх сунгах” гэсэн хүсэлтийг дарснаар зайнаас сунгах боломжтой ба үйлчилгээний хураамжийг Худалдаа, хөгжлийн банкны төлбөр тооцооны дундын / клиринг/ данснаас автоматаар суутгана.

Онлайн үйлчилгээний эрх

Үйлчилгээний эрх:

Арилжааны

Эрх сунгах

Арилжааны эрх дуусах хугацаа:

Хаагдсан

Эрх цуцлах

Төлбөр тооцооны данс

Энэ хэсэгт таны үнэт цаасны арилжааны хэлцлийн дүнд үүссэн төлбөр тооцоо, мөнгөн хөрөнгийн гүйлгээтэй холбоотой данснуудын мэдээллийг харуулна. Хоёрдогч зах зээлийн арилжаанд тогтмол ашиглагддаг төлбөр тооцооны дансны мөнгөн хөрөнгийн гүйлгээний мэдээллийг цаг хугацааны хоцрогдолгүйгээр /онлайн/ хянах, хуулга харах боломжтой.

Анхдагч зах зээлд ашиглагддаг Арилжааны төлбөр тооцооны данс болон ногдол ашиг тараалттай холбоотой Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвийн дансны мэдээллийг брокертоо хандан авах боломжтой.

№	Данс	Дансанд хадгалагдах хөрөнгө	Дансны зориулалт	Дансанд мөнгөн орлого орох тохиолдлууд	Данснаас мөнгөн зарлага гаргах
2	ТӨЛБӨР ТООЦООНЫ ДУНДЫН ДАНС <i>(клиринг,эскроу)</i>	Мөнгөн хөрөнгө	Хоёрдогч зах зээлийн арилжааны мөнгөн төлбөр тооцоог гүйцэтгэх	- Хоёрдогч зах зээл дээрээс үнэт цаас худалдан авах мөнгөн хөрөнгөө байршуулах - Үнэт цаасаа худалдсан тохиолдолд, үнэт цаас худалдсан мөнгөн орлого дансанд шилжин орно.	- Онлайнаар мөнгө хүсэх өргөдөл илгээн дурын банкин дах дансандаа мөнгөө хүлээн авна. - Үнэт цаасны компани дээр ирж мөнгө хүсэх өргөдөл гаргаж болно.
3	ҮНЭТ ЦААСНЫ ТӨВЛӨРСӨН ХАДГАЛАМЖИЙН ДАНС <i>ҮЦТХТ</i>	Үнэт цаас Ногдол ашиг Ногдол хувь	Үнэт цаасны төвлөрсөн бүртгэл	- Хувьцаат компани ногдол ашгаа ҮЦТХТ-өөр дамжуулан хуваарилахаар шийдсэн бол тус ногдол ашгийн мөнгө - Компани татан буугдсан тохиолдолд хувьцаанд ногдох ногдол хувийн мөнгө орж болно.	Үнэт цаасны компани дээр ирж мөнгө хүсэх өргөдөл гаргана.
4	АРИЛЖААНЫ ТӨЛБӨР ТООЦООНЫ ДАНС	Мөнгөн хөрөнгө	Анхдагч зах зээлийн арилжааны төлбөр тооцоо гүйцэтгэх	- Анхдагч зах зээлийн арилжаанд оролцон үнэт цаас худалдан авах мөнгөө байршуулах - Таны худалдан авсан бондын эргэн төлөлт болон хүүгийн төлбөр энэ дансанд шилжин орно.	Үнэт цаасны компани дээр ирж мөнгө хүсэх өргөдөл гаргана.

6

Үнэт цаасны данс

Энэ хэсэгт таны эзэмшиж буй үнэт цааснуудын үлдэгдлийн мэдээллийг харуулах ба дансны шинжилгээ болон хуулга татаж авах боломжтой.

Зах зээл

Данс

Үнэт цаасны данс

Үнэт цаасны данс

71-99006132

Дансны үлдэгдэл

Дансны шинжилгээ

Хуулга

Хувьцаа

№	▲	Үнэт цаас	◆	Бизнесийн чиглэл	◆	Тоо ширхэг
2		SUU 		Үйлдвэрлэл		4
3		JLT 		Худалдаа үйлчилгээ		28

Дансны шинжилгээ (LIVE)

Энэ хэсэгт таны бодит бус ашиг/алдагдлын тайлан буюу мөнгөн хөрөнгийн позиц дүнг харуулна. Үүнд үнэт цаасыг худалдаж авсан дундаж үнийн мэдээлэл байх ба үүнийг зах зээлийн өнөөдрийн ханштай харьцуулан тооцож арилжааны ашиг/алдагдлын дүнг харуулна.

Зах зээл

Данс

Үнэт цаасны данс

Үнэт цаасны данс

71-99006132

Дансны үлдэгдэл

Дансны шинжилгээ

Хуулга

Хувьцаа

№	▲	Үнэт цаас	◆	Тоо ширхэг	◆	Дундаж үнэ	◆	Нийт	◆	Сүүлийн ханш	◆	Шимтгэлийн дүн	◆	Позиц	◆
2		SUU		4		236.00		944.00₮		228.00		18.24₮		-69.12₮	
3		JLT		28		261.45		7,320.60₮		132.00		73.92₮		-3,844.93₮	

Хуулга

Хуулга дээр дарснаар та үнэт цаасны болон төлбөр тооцооны дансны хуулгаа сонгон харж, Excel болон PDF форматаар татаж авах боломжтой.

4. ЗАХИАЛГА

Шинэ захиалга өгөх

Та сонирхож буй үнэт цаасныхаа арилжаанд орохоор шийдсэн бол энэ хэсэгт худалдах, худалдан авах захиалга өгнө.

Шинэ захиалга өгөх

+

Хоёрдогч
зах зээлийн захиалга

>

+

Анхдагч
зах зээлийн захиалга

>

Монголын хөрөнгийн бирж дээр арилжаалагдаж буй үнэт цаасны арилжаанд оролцох бол ХОЁРДОГЧ, анх удаа үнэт цаасаа олон нийтэд санал болгож байгаа буюу үнэт цаас гаргагчаас бусдад үнэт цаасаа худалдах арилжаанд оролцох бол АНХДАГЧ зах зээл гэдгийг сонгож үнэт цаасны худалдах, худалдан авах захиалгыг өгнө.

Шинэ захиалга Хоёрдогч зах зээлийн захиалга

Та үнэт цаас болон захиалгын төрлөө сонгоно уу

Хувьцаа

Авах Зарах

Үнэт цаасны нэр: LEND - ЛЭНДМН ББСБ

Захиалгын төрөл: НӨХЦӨЛТ

Биелэх нөхцөл: ЗАХИАЛГА ХИЙСЭН ӨДӨР

Үнэ: 0

Тоо хэмжээ: 0

Хүчинтэй хугацаа: 10/29/2018

Баталгаажуулах код: 154402

АВАХ ЗАХИАЛГА ӨГӨХ

Захиалгын тооцоолуур

Үнэт цаасны нэр: ЛЭНДМН ББСБ

Тоо хэмжээ: 0

Үнэ: 0

Хүчинтэй хугацаа: 2018-10-29

Захиалгын төрөл: Сонгох

Биелэх нөхцөл: Сонгох

Үнэт цаасны нэр: Худалдах/худалдан авах гэж буй үнэт цаасны нэр эсвэл кодыг оруулна.

Захиалгын төрөл:

Нөхцөлт: Худалдаж авах үнийн дээд түвшин, эсхүл худалдах үнийн доод түвшинг заасан захиалгыг хэлнэ.

Зах зээлийн захиалга: Тухайн үеийн зах зээлийн хамгийн сайн ханшаар (at the best price) үнэт цаасыг худалдах, эсвэл худалдан авах захиалгыг хэлнэ. Энэ нь захиалгын санд хадгалагдахгүй ба хэсэгчлэн биелсэн тохиолдолд, түүний биелэгдээгүй үлдсэн хэсэг нь 60 секундний дотор хүчингүй болно.

Биелэх нөхцөл: Захиалгын хүчинтэй хугацааг заана. Захиалга хийсэн өдөр: Захиалгын санд оруулсан тухайн өдрийн арилжааны эцэст цуцлагдах болно.

Цуцлагдах хүртэл: Захиалга цуцлагдах хүртлээ эсвэл хуанлийн 30 өдөр хүчинтэй байна.

Заасан өдөр хүртэл: Хэлцэл хийгдээгүй тохиолдолд захиалга нь заасан арилжаа өдөр дуусахад хүчингүй болно.

Үнэ: Хэрэв та нөхцөлт захиалга өгч байгаа бол үнийн саналаа энэ талбарт оруулна.

Тоо хэмжээ: Үнэт цаасны тоо ширхгийг оруулна.

Хүчинтэй хугацаа: Хэрэв та биелэх нөхцөлөө “Заасан өдөр хүртэл” гэж сонгосон бол энэ талбарт дуусах огноог оруулна.

Баталгаажуулах код: Текст дээрх бичвэрийг доорх талбарт оруулна.

Монголын үнэт цаасны арилжааны төлбөр тооцооны систем T+0/T+1 буюу урьдчилсан төлбөрт систем тул захиалга өгөхийн өмнө төлбөр тооцооны дансандаа мөнгөө байршуулсан байх шаардлагатай.

Захиалгын тооцоолуур

Үнэт цаасны нэр: ЛЭНДМН ББСБ

Тоо хэмжээ: 1,000

Үнэ: 85₮

Хүчинтэй хугацаа: 2018-10-30

Захиалгын төрөл: Сонгох

Биелэх нөхцөл: Сонгох

Захиалгын дүн: 85,000₮

Шимтгэлийн дүн: 1,700₮

Мөнгөн дүн: 86,700₮

Захиалгын тооцоолуур

Энэ талбар дээр таны өгсөн үнийн санал болон тоон ширхэгт үндэслэн шимтгэлийн хувь хэмжээг бодож, нийт мөнгөн дүнг тооцоолно. “Сануулах” товч нь цэс хооронд шилжих үед захиалгын цонхонд шивэгдсэн нөхцөлүүдийг хадгалах зориулалттай.

Захиалгын лавлагааны хэсэг

Захиалгын түүхээ энэ хэсгээс харна. Тодруулбал захиалга ямар төлөвт байгаа, хэзээ өгсөн, ямар захиалгын дугаартай зэрэг мэдээллүүдийг харахаас гадна захиалгын үнэ өөрчлөх, захиалга цуцлах, баримт харах зэрэг нэмэлт үйлдлүүд хийх боломжтой.

“Захиалгын төлөв” гэдэгт дараах утгууд агуулагдана. Үүнд:

Шинэ: Таны захиалга Хөрөнгийн биржийн системд (MIT) хараахан ороогүй байна.

Хүлээн авсан: Таны захиалга MIT системийн захиалгын санд орсон байна.

Төлөв шалгаж байна: Захиалга дуудлага арилжааны төлөвт орсон тул 5 минут хүлээнэ.

Цуцлагдсан: Захиалга цуцлагдсан байна.

Хэсэгчлэн биелсэн: Таны өгсөн захиалгаас зарим хэсэг нь биелсэн байна.

Биелсэн: Захиалга 100% биелсэн байна.


Захиалгын лавлагаа									
Огноо: 09/30/2018 - 10/30/2018		Төлөв: Бүгд ХАРАХ							
№	Захиалгын огноо	Захиалгын дугаар	Хуулга	Авах/зарах	Үнэт цаас	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Тайлбар	
1	2018.10.30	80561	Хүлээн авсан	Авах захиалга өгөх	ЛЭНДМН ББСБ	1	60		
2	2018.10.30	80543	Цуцлагдсан	Зарах захиалга өгөх	А.П.У	1	593		
3	2018.10.30	80540	Цуцлагдсан	Зарах захиалга өгөх	А.П.У	1	594		
4	2018.10.30	80537	Цуцлагдсан	Зарах захиалга өгөх	А.П.У	1	600		

Мөн сүүлийн долоо хоногийн захиалгын жагсаалт ил харагдах бөгөөд харилцагч огноо хэсэгт лавлагаа авах огноогоо оруулснаар тухайн хугацаан дахь захиалгын түүхээ харах ба захиалгын төлөвөөр шүүн харах боломжтой.


5. ГРАФИК ШИНЖИЛГЭЭ

Энэ хэсэгт үнэт цаасны шинжилгээтэй холбоотой үнэт цаасны үнэ ханш /price/, арилжааны идэвх болон арилжаалагдсан үнийн дүнгийн /volume/ мэдээллийг 4 төрлийн график хэлбэрээр харахаас гадна техник шинжилгээ хийх боломжтой.


1. “Line” график



2. “Candle” график



3. “Bar” график



2. “Multiple panel” график



6. АРИЛЖАА (LIVE)

Монголын хөрөнгийн бирж дээр арилжаалагдаж буй үнэт цааснуудыг “Арилжаа” цэсээс харж болно. Ингэхдээ (I), (II), (III)-аар ангилалд байгаа тухайн үнэт цаасны нээлтийн ханш, хамгийн дээд болон доод ханш, өмнөх өдрийн хаалтын ханш, сүүлийн ханш, өсөлтийн хувь зэрэг мэдээллүүд харагдахаас гадна захиалгын санд байгаа худалдан авах хамгийн дээд ханш, худалдах хамгийн доод ханшийг цаг хугацааны хоцрогдолгүй шууд харах боломжтой.

Монголын хөрөнгийн биржийн арилжааны самбар / LIVE /														
Хувьцаа	Нээлт	Дээд	Доод	Сүүлийн ханш	Өмнөх өдрийн хаалт	Хаалтын ханш	Өөрчлөлт ₮	Өөрчлөлт %	Тоо ширхэг	Авах үнэ	Авах тоо	Зарах үнэ	Зарах тоо	
MNDL	5,130.00	5,130.00	5,130.00	5,130.00	5,070.00	0.00	▲ 60.00	1.18 %	2	4,990.00	14	5,120.00	613	
APU	580.00	585.00	580.00	585.00	579.22	0.00	▲ 5.78	1.00 %	5,424	580.00	576	588.00	4,600	
NEH	20,000.00	20,000.00	20,000.00	20,000.00	19,070.00	0.00	▲ 930.00	4.88 %	20	19,000.00	10	21,200.00	50	
GOV	34,040.00	34,300.00	34,000.00	34,300.00	34,280.00	0.00	▲ 20.00	0.06 %	24	34,000.00	7	34,100.00	600	
AIC	760.00	770.00	760.00	770.00	760.00	0.00	▲ 10.00	1.32 %	2,678	760.00	540	770.00	182	
Энэ өдөр I ангилалд 5 компанийн нийт 8148 ширхэг хувьцаа 6,437,720.00 төгрөгөөр арилжигдсан байна.														
Хувьцаа	Нээлт	Дээд	Доод	Сүүлийн ханш	Өмнөх өдрийн хаалт	Хаалтын ханш	Өөрчлөлт ₮	Өөрчлөлт %	Тоо ширхэг	Авах үнэ	Авах тоо	Зарах үнэ	Зарах тоо	
MBW	318.00	318.00	318.00	318.00	318.10	0.00	▼ -0.10	-0.03 %	1,706	318.00	310	320.00	9,400	
BDS	970.00	970.00	970.00	970.00	970.00	0.00	▲ 0.00	0.00 %	180	965.00	200	1,000.00	300	
BAN	1,500.00	1,500.00	1,500.00	1,500.00	1,500.00	0.00	▲ 0.00	0.00 %	3	1,426.00	20	1,500.00	161	
Энэ өдөр II ангилалд 3 компанийн нийт 1889 ширхэг хувьцаа 721,608.00 төгрөгөөр арилжигдсан байна.														

“Ханш” гэдэгт дараах утгууд агуулагдана. Үүнд:

Нээлтийн ханш: Өдрийн хамгийн эхэнд хийгдсэн хэлцлээр тодорхойлогдоно.

Хаалтын ханш: Арилжаа нь Даваа-Баасан гарагт 10:00-13:00 цагийн хооронд явагддаг бөгөөд арилжааны сүүлийн 1 цагт хийгдсэн бүх хэлцлүүдийг тоо хэмжээгээр нь жигнэсэн дундаж ханшаар тодорхойлогддог.

Дээд ханш: Тухайн өдөрт хийгдсэн хэлцлүүдийн хамгийн өндөр ханш.

Доод ханш: Тухайн өдөрт хийгдсэн хэлцлүүдийн хамгийн бага ханш.

Сүүлийн ханш: Хамгийн сүүлд биелсэн хэлцлээр тодорхойлогдоно.

Өөрчлөлтийн хувь: Өмнөх өдрийн хаалтын ханш болон хамгийн сүүлд хийгдсэн хэлцлийн зөрүүг хувиар илэрхийлснээр тодорхойлогдоно.

7. МӨНГӨ ХҮСЭХ ӨРГӨДӨЛ

Үнэт цаасны арилжааны хэлцлийн дүнд үүссэн төлбөр тооцоо, мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй холбоотой зарлагын гүйлгээ хийхдээ уг цонхийг ашиглана.

Хоёрдогч зах зээлийн арилжаанд тогтмол ашиглагддаг төлбөр тооцооны дундын /клиринг/ данснаасаа зарлагын гүйлгээ хийхдээ брокертоо хандахгүйгээр мөнгө хүсэх өргөдөл зайнаас илгээж, өөрийн дурын банкны дансандаа мөнгөө татах боломжтой.

Анхдагч зах зээлд ашиглагддаг Арилжааны төлбөр тооцооны данс болон ногдол ашиг тараалттай холбоотой Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвийн дансны үлдэгдлээ брокертоо хандан татаж авах боломжтой.

Шинээр мөнгө хүсэх

Төлбөр тооцооны дундын данс

ҮЦТХТ-ны данс

АТТ-ын данс

САНАМЖ:
Таны илгээсэн мөнгө хүсэх өргөдөл нь зөвхөн ажлын өдрүүдийн ажлын цагаар хянагдаж, гүйлгээ хийгдэх болохыг анхаарна уу.

Мөнгө хүсэх өргөдлийн лавлагаа

огноо:

10/24/2018

 -

10/31/2018

үйлчилгээний эрх:

Төлбөр тооцооны данс

ХАРАХ

№	Илгээсэн огноо	Илгээсэн данс	Мөнгөн дүн	Хүлээн авах банк	Хүлээн авагчийн нэр	Тайлбар	Төлөв
1	2018/10/31 16:52:16	499000111	500.00₮	ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК	МАРГАД	Харилцах дансанд орлого	Хүлээгдэж байна.

“Шинээр мөнгө хүсэх” хэсгийн “Төлбөр тооцооны дундын данс” товчлуур дээр даран хүсэлтээ илгээнэ. Илгээсэн хүсэлтүүд “Мөнгө хүсэх өргөдлийн лавлагаа” хэсэгт харагдах бөгөөд тухайн өдөртөө зөвшөөрөгдөж таны хүлээн авах дансанд мөнгө шилжинэ.

Зарлага гаргах данс

499252625

Хүлээн авагчийн нэр

МАРГАД

Хүлээн авах банк

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК

Хүлээн авагчийн данс

499000111

Мөнгөн дүн

500

Тайлбар

Харилцах дансанд орлого

Баталгаажуулах код:

08203

Зарлага гаргах данс: Таны арилжааны буюу клирингийн дансны дугаар.

Хүлээн авагчийн нэр: Орлого хүлээн авах данс нь зөвхөн өөрийн нэр дээрх данс байна.

Хүлээн авагчийн банк: Орлого хүлээн авах банкаа сонгоно.

Хүлээн авагчийн данс: Дансны дугаараа оруулна.

Мөнгөн дүн: Зарлага гаргах мөнгөн дүнг оруулна.

Тайлбар: Гүйлгээний утгаа оруулна.

Баталгаажуулах код: Доорх текстийг зөв оруулах.

8. ШУУДАН

Компанийн зүгээс шуурхай мэдээ, мэдэгдэл болон хувьцаат компаниудын мэдээлэл судалгаа, хөрөнгийн зах зээлийн долоо хоногийн тойм, бусад судалгааны тайлан зэрэг нэмэлт мэдээллүүд байршина.

Харилцагчийн шуудан	
миний шуудан	7 хоногийн тойм
мэдээлэл	Огноо
7 хоногийн тойм	2018/09/19
судалгаа	2018/09/19
	2018/09/19
	2018/09/19
	2018/09/18

ТҮГЭЭМЭЛ АСУУЛТ, ХАРИУЛТ

Анхдагч зах зээлийн арилжаа гэж юу вэ?

Үнэт цаас гаргагч үнэт цаасаа нийтэд анх удаа санал болгон арилжихыг хэлнэ.

Тогтоосон үнээр санал болгох арилжаа гэж юу вэ?

Анхдагч зах зээлд олон нийтэд хувьцаагаа санал болгохдоо үнэт цаас гаргагчийн тогтоосон тодорхой үнээр санал болгон арилжих үйл ажиллагааг хэлнэ.

Үнэ хаялцуулах дуудлага арилжаа гэж юу вэ?

Анхдагч зах зээлд олон нийтэд хувьцаагаа санал болгохдоо үнэт цаасны багцыг тогтоосон үнээс эхлэн үнэ хаялцуулах арилжих үйл ажиллагааг хэлнэ.

Хоёрдогч зах зээлийн арилжаа гэж юу вэ?

Үнэт цаас гаргагч үнэт цаасаа нийтэд анх удаа санал болгон арилжсаны дараа үнэт цаасыг хөрөнгө оруулагчид хоорондоо дахин арилжихыг хоёрдогч зах зээлийн арилжаа гэнэ.

Хоёрдогч зах зээлийн арилжаа хэзээ эхэлдэг вэ?

Анхдагч зах зээлийн арилжаа дууссаны дараа СЗХ-ны зөвшөөрлөөр тухайн үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлнэ.

Арилжаа явагдах цаг гэж юу вэ?

Монголын хөрөнгийн биржээс амралтын өдөр хэмээн тодорхойлсноос бусад Даваа-Баасан гаригуудад арилжаа явагдана. Арилжааны цаг 10.00 -13.00 цагийн хооронд явагдана.

Хэлцэл хийгдэх дараалал гэж юу вэ?

Ханшийн эрэмбэ (Price priority): Хамгийн өндөр ханшаар худалдан авах, хамгийн бага ханшаар худалдах захиалга нь бусад захиалгаас өмнө биелэгдэх давуу эрэмбэтэй байна. Захиалгын санд шивэгдсэн нийт захиалгууд нь ханшийн дарааллаар эрэмбэлэгдэнэ.

Цаг хугацааны эрэмбэ (Time priority): Худалдан авах болон худалдах захиалгууд нь ханшийн ижил түвшинд биелэгдэх нөхцөл бүрдсэн бол цаг хугацааны хувьд эхэнд шивэгдсэн захиалгууд нь бусад захиалгаас өмнө биелэгдэх давуу эрэмбэтэй байна.

Багцын Арилжаа гэж юу вэ?

Үнэт цаасны томоохон багцын арилжааг үнэт цаасны ханшийн хэт хэлбэлзэл үүсгэхгүй гүйцэтгэх зорилгоор Монголын хөрөнгийн бирж нь багцын тусгайлсан арилжааг явуулна. Багцын Арилжаа хийх захиалгуудыг Энгийн Захиалгын Сангаас тусдаа Захиалгын Санд (Багцын Захиалгын Сан) бүртгэн авч, арилжаална. Багцын арилжаа нь МХБ-ээс гадуур, урьдаас хэлэлцэн тохирсон арилжаа учраас хэлцэлд оролцогч эсрэг талын арилжааны гишүүний тусгай кодыг (contra firm ID) шинээр захиалга шивэхдээ давхар оруулна.

Ханшийн хязгаар гэж юу вэ?

Бирж нь арилжаанд оролцогчдын захиалгыг хамгаалах зорилгоор ханшийн хязгаар /Price Bands/-ыг тогтоох ба тухайн өдрийн арилжааны туршид хувьцааны ханш өсөх, буурах хэлбэлзэл нь өмнөх өдрийн хаалтын ханшаас 15 хувиас илүүгүй байна.

Арилжаа түр зогсоох гэж юу вэ?

Техникийн саатал болон бусад давагдашгүй хүчин зүйлсийн улмаас арилжааны хэвийн явц алдагдсан тохиолдолд Энгийн арилжааны (Regular Trading hours) дундуур Монголын хөрөнгийн биржийн зүгээс зах зээлийг түр зогсоож (Market Halts) болно.

Зах зээлийг зогсоосон үед, оруулсан захиалгуудыг цуцалж болох боловч захиалгыг өөрчлөх, эсвэл шинээр захиалга оруулах боломжгүй байна.

Тухайн үнэт цаасны арилжаа түр зогсоох гэж юу вэ?

Монголын хөрөнгийн биржээс үнэт цаасны ханшийн хэт өөрчлөлт буюу ханшийн тогтоосон хязгаараас давсан үнэ бүхий хэлцэл хийгдэх нөхцөл бүрдсэн тохиолдолд тухайн үнэт цаасны арилжааг түр зогсооно.

Арилжааг тухайн арилжааны өдөрт тодорхой хугацаагаар эсвэл Монголын хөрөнгийн биржээр олон нийтэд мэдээлүүлэхээр компаниас албан ёсны мэдэгдэл хүргүүлэх хүртэл нэг өдрөөс илүү хугацаагаар зогсоож болно.

Зах зээлийн үнэлгээ гэж юу вэ?

Тухайн хувьцаат компанийн гаргасан хувьцааны тоо ширхгийг тухайн өдрийн үнэт цаасны арилжааны хаалтын ханшаар үржүүлж гаргасан үзүүлэлтийг хэлнэ.

Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хэдийд, хэн зарлан хуралдуулах шийдвэрийг гаргах эрхтэй вэ?

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/-ийн шийдвэрээр санхүүгийн жил дууссанаас хойш дөрвөн сарын дотор зарлан хуралдуулна.

Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох эрхтэй ХЭ-ийн бүртгэлийн өдрийг хэрхэн тогтоох вэ?

Компанийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг Компанийн тухай хуулийн 64.2-т заасны дагуу хурал зарлагч этгээд тогтоох бөгөөд хурал зарлагч этгээд нь хурлын зарыг хурал хуралдахаас 30 болон түүнээс багагүй хоногийн өмнө өдөр тутмын 2-оос доошгүй сонин, орон даяар нэвтрүүлгээ түгээдэг радио, телевиз болон Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан хувьцаа эзэмшигчиддээ мэдээлсэн өдрөөс хойш 10 дахь өдөр байхаар тогтооно.

“Эрдэнэс Таван Толгой” ХК-ны 1072 ширхэг хувьцаагаа хэрхэн шалгах вэ?

Иргэд өөрийн нэр дээрх хувьцааны тухай мэдээллийг Үнэт цаасны төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжийн төвд (ҮЦТТТХТ) хандаж авах бөгөөд www.schcd.mn цахим хуудсанд хандаж, шалгах боломжтой.

Цэнхэр ягаан тасалбарыг одоо хаанаас шүүлгэж яаж ашиглах талаар?

Цэнхэр ягаан тасалбараар 1995 оноос өмнө хувьцаа худалдан аваагүй бол хүчингүй юм. Таны нэр дээр ямар нэг хувьцаа байгаа эсэхийг үнэт цаасны төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжийн төвд хандаж авах боломжтой юм.

Холбогдох утас: 7011-3671, 7012-0460

Цахим хуудас: www.schcd.mn



Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Энхтайваны өргөн чөлөө - 19
Утас: +976 11 311914, 7010 0261, 7010 0263
Факс: +976 11 311944
Имэйл: info@tdbcapital.mn